
“ТАЛЫН УРГАХ НАРАН” ХХК-ИЙН НҮҮРС АЧИЛТ, БУУЛГАЛТЫН
ТАЛБАЙН 2024 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хянасан:

“Талын ургах наран” ХХК-ийн
Захирал

Hu Junguo

Боловсруулсан:

“Газарчандмань” ХХК

Э.Мөнгөнтуяа

Өмнөговь аймаг
Ханбогд сум

2024 он

ГАРЧИГ

1. Төслийн товч танилцуулга	3
2. Төслийн талбай, түүний орчны байгаль орчин, нийгэм-эдийн засгийн төлөв байдлын товч тодорхойлолт	4
3. Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт.....	6
4. Байгаль орчны менежментийн тухайн жилийн төлөвлөгөөний гол зорилт	8
5. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө.....	9
6. Байгаль орчинд нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө ¹²	
7. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө	12
8. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө.....	13
9. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	14
10. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө.....	15
11. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө.....	18
12. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнах төлөвлөгөө	19
13. Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөр.....	19

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Нүүрс ачилт, буулгалтын талбайн барилга байгууламжууд.....	4
Хүснэгт 2. Эрсдэлийн үнэлгээний матриц	6
Хүснэгт 3. Магадлалын үнэлгээний шалгуур.....	6
Хүснэгт 4. Үр дагаврын үнэлгээний шалгуур.....	6
Хүснэгт 5. Байгаль орчны асуудал, нөлөөлөл, эрсдэлийн үнэлгээ	7
Хүснэгт 6. БОМТ-ний зардлын задаргаа.....	8
Хүснэгт 7. Байгаль орчныг хамгаалах арга хэмжээний нийт зардал	8
Хүснэгт 8. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	9
Хүснэгт 9. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө.....	13
Хүснэгт 10. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	14
Хүснэгт 11. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	15
Хүснэгт 12. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө.....	18
Хүснэгт 13. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсэд	19
Хүснэгт 14. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	20

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Нүүрс ачилт, буулгалтын талбайн план зураг	3
Зураг 2. Нүүрс ачилт, буулгалтын талбайн байршил	5


ТОВЧИЛСОН ҮГ

БОАЖСайд	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд
БОМТ	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө
БОХТ	Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө
БОЯБ	Биологийн олон янз байдал
ОХШХ	Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөр

1. Төслийн товч танилцуулга

“Талын ургах наран” ХХК нь авто машины засвар үйлчилгээ, авто машины сэлбэгийн худалдаа, авто машины түрээсийн үйлчилгээ болон авто машинаар ачаа тээвэрлэх чиглэлээр үйл ажиллагаа эрхлэхээр 2020 оны 6 дугаар сард байгуулагдсан бөгөөд одоогийн байдлаар Өмнөговь аймгийн Ханбогд сумын 1 дүгээр багийн нутаг дэвсгэрт нүүрс ачилт, буулгалт, тээвэрлэлтийн үйл ажиллагаа явуулж байна.

Тус компанийн нүүрс ачилт, буулгалтын талбай нь нийт 200 мян.м² талбайг хамрах бөгөөд уг талбайн орох, гарах хаалганаас бусад газраар бараа, тээврийн хэрэгсэл, хувь хүн нэвтрэх боломжийг хаасан, хэвийн, аюулгүй байдалд ажиллах ажлын байр, амьдрах сууц болон галын дохиоллын систем, гал унтраах багаж хэрэгслээр тоноглогдсон, зам талбай, зогсоолыг тэгшилж, зам гаргасан, нүүрс ачилт, буулгалтын талбай, зогсоолд стандартад заасан аюулгүй ажиллагааны тэмдэг, тэмдэглэгээг байршуулсан, хяналтын камерыг нийт талбайн орчин бүхэлдээ харагдахаар шаардлагатай тоо хэмжээгээр байрлуулсан ба 24 цагийн харуул хамгаалалттай.



Зураг 1. Нүүрс ачилт, буулгалтын талбайн план зураг

“Талын ургах наран” ХХК-ийн Нүүрс ачилт, буулгалтын талбайд дараах барилга байгууламж байрлах бөгөөд ажилчдын амьдрах байр, офиссыг нам даралтын зуухаар халаадаг. Цахилгаан эрчим хүчинд холбогдсон. Усны худаг байхгүй, унд ахуйн хэрэгцээ болон зам талбайн усалгаанд зөөврийн ус ашигладаг.

Хүснэгт 1. Нүүрс ачилт, буулгалтын талбайн барилга байгууламжууд

№	Барилга, байгууламжийн нэр	Тоо ширхэг
1	Гаалийн хяналтын офиссын байр	1
2	Амьдрах сууц	27 өрөө
3	Хоолны газар	1
4	Хурлын танхим	1
5	Хучилтын байгууламж	1
6	Хучигчийн байр	1
7	Автоачигчийн операторын байр	1
8	Тээврийн мэргэжилтэн, зохицуулагчийн байр	1
9	Харуулын байр	1
10	Нийтийн ариун цэврийн байр	1
11	Хог хадгалах цэг	1
12	Пүүлэгчийн байр	1
13	Автожин (пүү)	1
14	Гэрэлтүүлгийн цамхаг	1
15	Авто гараж	1

2. Төслийн талбай, түүний орчны байгаль орчин, нийгэм-эдийн засгийн төлөв байдлын товч тодорхойлолт

“Талын ургах наран” ХХК-ийн Нүүрс ачилт, буулгалтын талбай нь Өмнөговь аймгийн Ханбогд сумын 1 дүгээр багийн нутаг дэвсгэрт, Улаанбаатар хотоос өмнө зүгт 830 км, Өмнөговь аймгийн төв Даланзадгад сумаас зүүн урд зүгт 340 км, Ханбогд сумын төвөөс баруун өмнө зүгт 120 км, Монгол-Хятадын хилийн боомт Гашуун Сухайтаас 20 гаруй км-ийн зайд оршино.



Зураг 2. Нүүрс ачилт, буулгалтын талбайн байршил

“Талын ургах наран” ХХК-ийн Нүүрс ачилт, буулгалтын талбай нь газар зүйн хувьд Галбын говийн нутаг дэвсгэрт хамаарна. Галбын говь нь Монгол орны хамгийн нам дор оршдог говь цөлийн тэгш талархаг нутаг юм. Ерөнхий өндөршил нь далайн түвшнээс дээш нь 937.3 м - 1202.3 м хооронд хэлбэлзэнэ. Уур амьсгалын хувьд эх газрын эрс тэс уур амьсгал давамгайлдаг. Хавар намартаа сэрүүн, зундаа халуун, өвөл нь хүйтэн. Хавар нь хуурай салхитай, үе үе хүчтэй шуурдаг. Температурын хэлбэлзэл маш их буюу өвөлдөө доод тал нь -31°C , зундаа 40°C -аас илүү байдаг. Нүүрс ачилт, буулгалтын талбай орчмын нутаг дэвсгэр хүн ам цөөтэй, үйлдвэрлэл дэд бүтэц сул хөгжсөн, хүрээлэн буй орчны агаарт нөлөөлөх хог хаягдлын томоохон эх үүсвэр, бохирдуулагч эх үүсвэр байхгүй. Улирлын шинж чанартай шороон шуургыг эс тооцвол энэ бүс нутаг нь үндсэндээ цэвэр цэнгэг агаартай.

Хөрсний хувьд говийн хөрсний төрөлд хамаарах 3 дэд төрлийн буюу цөлийн цайвар бор, цөлөрхөг хээрийн цайвар бор, цөлөрхөг хээрийн саарал бор хөрс давамгайлна. Талбайн орчмын ургамал нь Төв Азийн цөл болон цөлөрхөг хээрийн ургамлын аймгийн төрөлд багтах ба цөлийн өргөн уудам тэгш тал, нам толгод нь ган гачигт тэсвэртэй жижиг бут, сөөгөөр армаг тармаг бүрхэгдсэн. Түр зуурын урсгалтай голын гольдролууд, хуурай жалгууд болон шал хөрс нь зарим зүйлийн мод ургах нөхцлийг бүрдүүлэх бөгөөд бутнууд нь гүний ус ойрхон байдаг газруудад голчлон ургасан байна. Ханбогд сумын нутаг хөхтөн амьтдын төрөл зүйлээр баялаг бөгөөд бүс нутгийн болон олон улсын хэмжээнд ховор тууртан амьтад болох хулан, хар сүүлт зээр, аргаль, янгир тархан байршсан байдаг.

3. Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт

ISO 14001:2016 Байгаль орчны менежментийн тогтолцоо Шаардлага, хэрэглэх арга зүйн заавар стандартын дагуу компанийн зүгээс байгаль орчны гүйцэтгэлийг сайжруулах зорилгоор байгаль орчны асуудлууд тэдгээрээс улбаатай байгаль орчны нөлөөллүүдийг тодорхойлж, эрсдэлийн үнэлгээ хийсэн.

Эрсдэлийн үнэлгээгээр байгаль орчны гол асуудлуудыг тодорхойлсон бөгөөд цаашид байгаль орчны чиглэлээр хийх ажлын ач холбогдлын эрэмбэ дарааллыг тогтоосон.

Эрсдэлийн үнэлгээний матриц

ISO 14001:2016 Байгаль орчны менежментийн тогтолцоо Шаардлага, хэрэглэх арга зүйн заавар стандартын дагуу байгаль орчны гүйцэтгэлийн ач холбогдлын дарааллыг тодорхой болгох зорилгоор эрсдэлийн үнэлгээг хийсэн. Байгаль орчны асуудлыг тодорхойлж, тэдгээртэй холбоотой байгаль орчны нөлөөллийг тодорхойлсон. Нөлөөлөл тус бүрийн эрсдэлийн зэргийг тодорхойлсон.

Хүснэгт 2. Эрсдэлийн үнэлгээний матриц

Магадлал	Үр дагавар				
	Ялимгүй	Бага	Дунд	Их	Гамшиг
I бараг болохгүй	L	L	M	H	H
II магад болохгүй	L	L	M	H	E
III болзошгүй	L	M	H	E	E
IV магад болох	M	H	H	E	E
V лавтай болох	H	H	E	E	E

Хүснэгт 3. Магадлалын үнэлгээний шалгуур

Түвшин	Зэрэг	Тайлбар
I	Бараг болохгүй	Онцгой нөхцөлд эрсдэлтэй байж магадгүй (<5%)
II	Болохгүй байж магад	Заримдаа эрсдэлтэй байж магадгүй (5-20%)
III	Болзошгүй	Заримдаа эрсдэл үүснэ (20-50%)
IV	Магад болох	Бараг бүх нөхцөлд эрсдэл үүсгэж болзошгүй (50-70%)
V	Лавтай болох	Бараг бүх нөхцөлд эрсдэлтэй (70-100%)

Хүснэгт 4. Үр дагаврын үнэлгээний шалгуур

Зэрэглэл	Уршиг	Эрсдэлд өртөгч ба эрсдэлийн тодорхойлолт		Эрсдэлд өртөгч ба эрсдэлийн тодорхойлолт
		Хүн ам	Эд хөрөнгө	
I	Ялимгүй	Техноген нөлөө арилахад хор уршиг арилна.	Хохиролгүй	Тусгай шийдэл шаардлагагүй.
II	Бага	Бүс нутагт хуримтлагдах нөлөөлөл бий болгож био орчинд стресс учруулна.	Багавтар хохиролтой	Уламжлалт арга хэмжээ, одоогийн горимыг мөрдөх.

III	Дунд	Урт хугацаанд дэлхийн дулааралд хувь нэмэр оруулна.	Дунд зэргийн хохиролтой	Уламжлалт арга хэмжээ, одоогийн чанд горимыг мөрдөх, зохион байгуулалтын өндөр түвшинд ажиллах.
IV	Их	Хуримтлагдах сөрөг нөлөө үүсгэж урт хугацаанд экологийн тэнцвэр алдагдана.	Их хохиролтой	Орчин үеийн технологи, өндөр сонор сэрэмж, зохион байгуулалтын хоршил, тодорхой хэмжээний хөрөнгө зардал шаардана.
V	Гамшиг	Байгаль орчинд эргэж буцахааргүй уршиг учруулж экологийн тэнцвэрт байдал алдагдахад хүрнэ.	Маш их хохиролтой	Орчин үеийн технологи, өндөр сонор сэрэмж, зохион байгуулалтын хоршил, их хэмжээний хөрөнгө оруулалт шаардана.

Хүснэгт 5. Байгаль орчны асуудал, нөлөөлөл, эрсдэлийн үнэлгээ

Үйл ажиллагаа	Асуудал	Нөлөөлөл	Магадлал	Үр дагавар	Эрсдэлийн зэрэглэл	Хариу арга хэмжээ
1	2	3	4	5	6	7
Ажилчдын амьдрах байр	Халаалт	Хүлэмжийн хий үүснэ.	4	1	II	Мод тарих
			4	1	II	Түлшний зарцуулалтын хяналт
	Хог хаягдал	Ландфилийн талбай нэмэгдэнэ.	5	4	IV	Хог хаягдлын ангилан ялгалт
			5	4	IV	Хог хаягдлын гарцыг хянах
Оффисын байрны үйл ажиллагаа	Дулааны хэрэглээ	Хүлэмжийн хий үүснэ.	4	1	II	Мод тарих
			4	1	II	Түлшний зарцуулалтын хяналт
Ус хангамж (ахуйн)	Усны хэрэглээ	Усны эх үүсвэр багасна.	4	2	II	Усны хэрэглээний хяналт
Ус хангамж (талбайн)			4	4	IV	Нөөцийн хэмнэлт
Хоол үйлдвэрлэл	Хог хаягдал	Ландфилийн талбай нэмэгдэнэ.	4	4	IV	Усны хэрэглээний хяналт
			5	2	III	Хог хаягдлын ангилан ялгалт, дахин боловсруулалт
Цахилгааны хэрэглээ (амьдрах байр, оффис)	Цахилгааны хэрэглээ	Хүлэмжийн хий үүснэ.	5	2	III	Хог хаягдлын гарцыг хянах
			5	1	II	Нөөцийн хяналт
Цахилгааны шугам	Шувууны анхааралд өртөнө.	Шувуу эндэх.	5	1	II	Цахилгааны хэрэглээний хяналт
			3	4	IV	Төлөвлөлтийг сайжруулах
			3	4	IV	БОЯБ мониторинг

4. Байгаль орчны менежментийн тухайн жилийн төлөвлөгөөний гол зорилт

Тус байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь "Талын ургах наран" ХХК-ийн Нүүрс ачилт, буулгалтын талбайн үйл ажиллагаанд байгаль орчны нийцлийг хангуулах гол зорилготой.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь байгаль хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрөөс бүрдэнэ.

Энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөөг Монгол Улсын Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн шинэчилсэн найруулга, БОАЖСайдын 2014 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн А/117 дугаар тушаалын 4 дүгээр хавсралт болон БОАЖСайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/618 дугаар тушаалын хавсралтын дагуу холбогдох дүрэм журмын шаардлагад нийцүүлж боловсруулав.

Хүснэгт 6. БОМТ-ний зардлын задаргаа

№	Ажлын нэр	Зардал (мян.төг)
1	Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний зардал	26650
2	Байгаль орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрийн зардал	4850
3	БОМТ-ний хэрэгжилтийг нөлөөллийн бүсэд оршин суугчид тайлагнах	1200
	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал	32700

5. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө нь байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах талаар авч хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө бөгөөд уг төлөвлөгөөнд нүүрс ачилт, буулгалтын талбайн үйл ажиллагаанаас байгаль орчинд нөлөөлөх нөлөөллийг бууруулах арга хэмжээ, шаардагдах хөрөнгө зардал, дагаж мөрдөх дүрэм журам, стандартуудыг нэгтгэн үзүүлсэн.

Хүснэгт 7. Байгаль орчныг хамгаалах арга хэмжээний нийт зардал

№	Ажлын нэр	Зардал (мян.төг)
1	Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ	8900
2	Ногоон байгууламж байгуулах төлөвлөгөө	11250
3	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	-
4	Түүх соёлын дурсгалыг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	-
5	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	2500
6	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	3000
7	Удирдлага, зохион байгуулалтын чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний нийт зардал	1000
	Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний нийт зардал	26650

6. Байгаль орчинд нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Хүснэгт 8. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (төг)	Тоо хэмжээ	Нийт зардал (төг)	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	9	
Агаар									
1	Хүнд машин механизмын хөдөлгөөнөөс тоосжилт бий болох	Талбайн ашиглалтын замыг сайжруулж хайрган хучилт хийх	Зам, талбай	га		5	6450000	Жилийн турш	Агаарын тухай хууль, Агаарын чанар Техникийн ерөнхий шаардлага (MNS 4585:2016)
		Зам талбайд усалгааны машиныг тогтмол ажиллуулах	Зам, талбай	ширхэг	Үйл ажиллагааны зардал	1		Жилийн турш	
		Дотоод зам талбайд зорчиж буй машин механизмуудад хурдны хязгаар тогтоож, гэнэтийн хэмжилт шалгалт хийж хяналт тавих	Зам, талбай	удаа	Үйл ажиллагааны зардал	Сард 3		Жилийн турш	
2	Нүүрс тээвэрлэлтээс үүссэн тоосжилт, агаарын бохирдол үүсэх	Нүүрс тээвэрлэж буй тээврийн хэрэгслийн ачааг хучиж бүтээх	Нүүрс ачилтын талбай			Тогтмол	-	Жилийн турш	Агаарын чанар Техникийн ерөнхий шаардлага (MNS 4585:2016)
	Тээврийн хэрэгслүүдийн хөдөлгүүр болон	Ашиглаж буй техник хэрэгслүүдийг автотээврийн хяналтын үзлэгт оруулах	Талбайд ажиллаж буй тээврийн хэрэгсэл	удаа		Жилд 1	1850000	Жилд 1 удаа	

3	нам даралтын зуухны яндангаар хорт хий ялгарч агаар орчныг бохирдуулах	Нам даралтын зуухны яндангаар ялгарах хорт хийн хэмжилт хийх, хяналт тавих	Ажилчдын амьдрах байр	ширхэг		1	-	Жилд 1 удаа	
---	--	---	--------------------------	--------	--	---	---	-------------	--

Хөрс

4	Талбайн хөрсний доройтол бохирдол үүсэх	Талбайд тээврийн хэрэгсэл, машин механизмыг тусгай зассан зам, талбайгаар зорчуулах, зам талбайд дэвсэлт хийх	Талбайн хэмжээнд	-	Үйл ажиллагааны зардал	12	Үйл ажиллагааны зардал	Сар бүр	
5	Ахуйн хог хаягдал ил задгай тархах, орчин бохирдуулах	Ахуйн хатуу хог хаягдал хуримтлуулах битүүмжлэл сайтай цэгийг шинэчлэн засах, хог хаягдлыг ангилан ялгах	Ахуйн хог хаягдал	-	Хог хаягдлын менежмент	-	Хог хаягдлын менежмент	Жилд 1 удаа	Хог хаягдлын тухай хуулийн 10.2.1, 10.2.2
6	Дулааны улиралд ахуйн хог хаягдал ялзарч муудах, орчинд таагүй үнэр тархах	Шаардлагатай газруудад ариутгал халдваргүйжүүлэлтийг мэргэжлийн байгууллагаар хийлгэж байх	Ахуйн хог хаягдал	удаа	300000	2	600000	Дулааны улиралд	Ахуйн шавж мэрэгч устгал, халдваргүйтгэлийн үйл ажиллагаанд мөрдөх эрүүл ахуй, халдвар хамгааллын үлгэрчилсэн дүрэм ¹
7	Үйл ажиллагааны явцад буруутай үйл ажиллагаа, санамсаргүй байдлаар түлш, шатахуунаар хөрс бохирдох	Хэрэв буруутай үйл ажиллагаанаас үүдэлтэй хөрс бохирдуулсан тохиолдолд хөрсийг цэвэрлэх, нөхөн сэргээх арга хэмжээг авах	Талбайн хэмжээнд	-	-	-	Компанийн зардлаар	Тухай бүр	Хөрс хамгаалах цөлжилтөөс сэргийлэх тухай хуулийн 9.3
		Хөрсний төлөв байдал, бохирдолд хяналт тавих, хөрснөөс дээж авч, мэргэжлийн байгууллагаар шинжлүүлэн дүгнэлт гаргуулах	Хөрсний бохирдол үүсгэж болзошгүй байршил	мг/кг	ОХШХ-т тусгагдсан	Жилд 2-3	ОХШХ-т тусгагдсан	ОХШХ-т тусгагдсан хуваарийн дагуу	MNS 5850:2019 Хөрсний чанар. Хөрсөнд агуулагдах бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ
Нийт							8900000		

¹ МХЕГ-ын 2017.11.01-ний өдрийн даргын А/179-р тушаал

Агаарын чанарт үзүүлэх нөлөөллийг бууруулах төлөвлөгөө

Тоос бууруулах технологийн ажил

Нүүрс ачилт, буулгалтын талбайн замыг сайжруулах: Тоосжилтыг бууруулах зориулалтаар усаар зам, талбайг чийглэх уламжлалт аргыг хэрэглэнэ. Мөн нүүрс ачилт, буулгалтын талбайн зам талбайд техникийн хөдөлгөөнөөр тоос бага үүсгэдэг материалаар дэвсэлт хийнэ.

Аюулгүй ажиллагааг хангах халтиргаа гулгаанаас сэргийлэх зорилгоор зам талбайн усалгааг ихэнхдээ дулааны улирал буюу гадаргуу дээр ус хөлдөхөөргүй гадаад орчны нөхцөлд хийнэ. Зам талбайн усалгаанд хурдгийн усыг аль болох бага, хур тунадсаар газрын гадаргад хуримтлагдсан усыг түлхүү ашиглахыг зорино.

Нүүрс ачилт, буулгалтын талбайд усалгааны машиныг тогтмол ажиллуулах: Талбайн хэмжээнд усалгааны машиныг жилийн турш усалгаанд тогтмол ашиглана.

Нүүрс ачилт, буулгалтын талбайн зам талбайд зорчиж буй машин механизмуудад хурдны хязгаар тогтоож, гэнэтийн хэмжилт шалгалт хийж хяналт тавих: Сар бүр талбайн хөдөлгөөнт техникүүдэд хяналт шалгалтыг Хөдөлмөрийн аюулгүй байдал хариуцсан инженерийн удирдлаган дор тогтмол хийж гүйцэтгэн бүртгэл хөтөлж, хурдыг зөвшөөрөгдсөн хэмжээнээс хэтрүүлсэн ажилтнуудад арга хэмжээ авч нийтэд мэдээлэх байдлаар хурдны хязгаарыг байнга мөрдүүлж ажиллана.

Нүүрс тээвэрлэлтийн машинуудын хяналт: Нүүрсний тээвэрлэлт хийж буй машинуудыг бүтээлэгтэй байлгаж, зөвшөөрөгдсөн замын маршрутын дагуу тээвэрлэлт хийж байгаа эсэхэд тогтмол хяналт тавьж ажиллана.

Ашиглаж буй техник хэрэгслүүдийг автотээврийн хяналтын үзлэгт оруулах: Талбайд ашиглагдаж буй тээврийн хэрэгслүүдийг жилд нэг удаа тогтсон хугацаанд үзлэгт хамруулж ажиллана. Мөн дотооддоо техникийн үзлэг шалгалтыг хуваарь гаргаж долоо хоног бүр хамруулж, утаа их хаядаг, стандартад нийцэхгүй тээврийн хэрэгслийг ажлын талбайд гаргахгүй байх талаар хяналт тавьж ажиллана.

Нам даралтын зуухны яндангаар ялгарах хорт хийн хэмжилт хийх, хяналт тавих: Амьдрах байрны уурын зуухнаас ялгарах утааны шинжилгээний хэмжилтийг итгэмжилсэн лабораторид шинжлүүлж стандарт хэмжээнээс хэтрүүлэхгүй байх арга хэмжээг авч ажиллана.

7. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө

Тухайн бүс нутаг нь салхины нөлөөлөл ихтэй, мөн нүүрсний тээвэрлэлтийн үйл ажиллагаанаас цөлжилтийн үйл явц эрчимтэй явагдаж, тоосжилт ихээр үүсэх болсон байна. “Талын ургах наран” ХХК нь Нүүрс ачилт, буулгалтын талбайдаа “Тэрбум мод” хөтөлбөрийн хүрээнд 1000ш модыг орон нутгаас заасан талбайд нэгдсэн журмаар тарихаар төлөвлөв.

Хүснэгт 9. Орчны тохижилт, “Тэрбум мод” хөтөлбөрийн төлөвлөгөө

№	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал (төг)	Нийт зардал (төг)	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	9	
1	“Тэрбум мод үндэсний хөтөлбөр” - ийн хүрээнд		Ажилчдын байрлах хэсэг	ш	1000	11250	11250000	9-р сард	Орон нутгаас нэгдсэн зохион байгуулалттай хийгдэх ажил
	Нийт						11250000		

8. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Өмнөговь аймгийн Ханбогд сумын 1 дүгээр баг, Цагаан хад орчмын нутаг дэвсгэрт өмнө хийгдсэн палеонтологи, археологийн урьдчилан хайгуул, судалгааны ажлын дүгнэлтэд археологи, палеонтологийн дурсгал илрээгүй гэсэн байдаг. Иймд “Талын ургах наран” ХХК-ийн Нүүрс ачилт, буулгалтын талбайн түүх соёлын өвийг хамгаалах төлөвлөгөөг боловсруулаагүй болно. “Талын ургах наран” ХХК нь цаашид нэмж барилга байгууламж барих тохиолдолд газар шорооны ажлын үед газрын хөрсөн доороос мэдэгдээгүй үлдсэн соёлын биет өв илэрсэн тохиолдолд Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 38.3-т зааснаар “Газрын хэвлийг эзэмших, ашиглах явцад соёлын биет өв илэрвэл газрын хэвлийг ашиглагч ажлаа зогсоож, энэ тухай сум, дүүргийн Засаг дарга, цагдаагийн болон уг асуудлыг хариуцсан байгууллагад нэн даруй мэдэгдэнэ” гэж заасныг баримтлан ажиллана.

9. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Энэхүү төлөвлөгөөнд байгалийн аюул, гамшиг, гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын хэмжээ, шаардагдах зардал, баримтлах стандартыг тусгасан.

Хүснэгт 10. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал (төг)	Нийт зардал (төг)	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
1	Байгалийн аюул, гамшгийн нөхцөл байдал үүсэх	Нүүрс ачилт, буулгалтын талбайн Гамшгаас хамгаалах төлөвлөгөө, Аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулж батлуулах	Талбайн хэмжээнд	-	-	-	Жилдээ	Гамшгаас хамгаалах тухай хууль
		Гамшгаас хамгаалах төлөвлөгөө, Аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөөг нийт ажилтнуудад танилцуулах	Талбайн хэмжээнд	>30 хүнд	-	ХАБЭА-н зардалд тусгана.	Улиралд 1 удаа	
		Үерийн эрсдэл бүхий цэгүүдэд байгуулсан ус зайлуулах суваг шуудууг сэргээх	Талбай, амьдрах байр	-	-	Үйл ажиллагааны зардал	Жилийн турш	Усны тухай хууль, Хот тосгоны төлөвлөлт барилгажилтын норм ба дүрэм БНБД-30.01.03
2	Гал түймрийн аюул үүсэх	Галын аюулаас урьдчилан сэргийлэх дүрэм, журам боловсруулж түүнийг дагаж мөрдөх	Талбайн хэмжээнд	-	-	-	Жилдээ	Гамшгаас хамгаалах тухай хууль
		Галын дохиоллын систем суурилуулах, гал унтраах хэрэгслийг зохих газруудад байрлуулах, байнгын бэлэн байлгах, аюулын гарцын байрлалын заасан самбар галын аюул болж болзошгүй газруудад анхааруулах зурагт хуудас, тэмдэг тэмдэглэгээг байрлуулах, хяналт тавих	Талбайн хэмжээнд	-	2500000	2500000	Жилдээ	Гамшгаас хамгаалах тухай хууль, MNS 4244:1994 Хөдөлмөр хамгааллын систем, галын аюулгүй байдал. Ерөнхий шаардлага
	Нийт					2500000		

10. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Нүүрс ачилт, буулгалтын талбайн үйл ажиллагаанаас үүсэх хог хаягдлаас хүний эрүүл мэнд болон байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг бууруулах, арилгах зорилгоор хог хаягдлын зохистой удирдлагыг хэрэгжүүлэхэд төлөвлөгөөний зорилго оршино. Хүний амьдрах орчин, эрүүл мэндэд учруулах хог хаягдлын сөрөг нөлөөг илрүүлэн зохих арга хэмжээ авахад хэрэглээ, бүтээгдэхүүний сонголтыг харгалздаг дэлхий нийтийн хандлага бий болж байгаад анхаарч ажиллана. 2024 онд ажилчдын ахуйн бохирыг цэвэршүүлэх төхөөрмж бүхий стандартад нийцсэн ОО-той болох төлөвлөгөөтэй байна. Энэ ажилтай холбоотой “Эколог” зэрэг байгууллагаас үнийн санал авах, судалгааны ажил хийж эхлээд байна.

Хүснэгт 11. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (төг)	Тоо хэмжээ	Нийт зардал (төг)	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	9	
		Ахуйн хатуу хог хаягдал хуримтлуулах цэгийг шинэчлэх, битүүмжлэл сайтай болгох	Ахуйн гаралтай хатуу хог хаягдал	төгрөг	600000	-	600000	Жилдээ	Хог хаягдлын тухай хуулийн 10.2.2, 15 дугаар зүйл
1	Ахуйн	Хог хаягдал ангилан ялгах хогийн сав худалдаж авах	Ахуйн гаралтай шингэн хаягдал	төгрөг	900000	1	900000		
		Хог хаягдлыг ангилан ялгаж, түр хуримтлуулах, дахин ашиглах, боловсруулах боломжтой хаягдлаас бусад хог хаягдлыг нэгдсэн хогийн цэгт тээвэрлэх зайлуулах	Ахуйн гаралтай хатуу хог хаягдал	-	-	-	Үйл ажиллагааны зардал	Байнга	Хог хаягдлын тухай хуулийн 4.1.7, 10.2.1, Энгийн хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, ... үйл ажиллагаанд тавигдах ерөнхий шаардлага

	Орон нутгийн захиргааны байгуулагатай хог хаягдлын гэрээ байгуулж, төлбөр төлөх	Ахуйн гаралтай хатуу хог хаягдал	төгрөг	Орон нутгаас тогтоосон тарифын дагуу	-	Орон нутгаас тогтоосон тарифын дагуу	Жил бүр	Хог хаягдлын тухай хуулийн 10.2.7, Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээг тооцох аргачлал
--	---	----------------------------------	--------	--------------------------------------	---	--------------------------------------	---------	---

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (төг)	Тоо хэмжээ	Нийт зардал (төг)	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	9	
1	Ахуйн	Ангилсан хог хаягдлаас дахин ашиглах, боловсруулах хог хаягдлыг түүхий эдийн цэгт нийлүүлэх	Ахуйн гаралтай хатуу хог хаягдал	-	-	-	Үйл ажиллагааны зардал	Тухай бүр	Энгийн хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаанд тавигдах ерөнхий шаардлага ² ын 2.2.2.а
		Ажилчдад хог хаягдлыг бууруулах, ангилах, дахин ашиглах, зүй зохистой хаях дадал зуршлыг хэвшүүлэх, яриа таниулга хийх	Ахуйн гаралтай хатуу хог хаягдал	-	-	-	1500000	Байнга	Хог хаягдлын тухай хуулийн 10.2.8, 10.2.16
		Ажилчдын оо -г эко болгон тохижуулж хөрс бохирдуулахгүй байх стандартад нийцсэн болох , /"Эколос" зэрэг/	Ахуйн гаралтай шингэн хог хаягдал	ш				Үйл ажиллагааны зардал	2024 онд багтааж
2	Үйлдвэрийн	Хаягдал дугуйг замын хаалт, хашилтанд дахин ашиглах	Тээврийн хэрэгслийн ашиглалтаас гарсан дугуй	-	-	-	Үйл ажиллагааны зардал	Тухай бүр	Эх үүсвэрээс гарах хог хаягдлын кодчилсон жагсаалт, тэдгээрийн зэрэглэл ³
		Халаалтын зуухны үнсийг тусгай саванд хуримтлуулж, богино хугацаанд тээвэрлэн зайлуулах	Ажилчдын байрны халаалтын зуух	-	-	-		Үйл ажиллагааны зардал	Тухай бүр
	Нийт						3000000		

11. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

Хүснэгт 12. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хуваарь				Хариуцсан албан тушаалтан
			2024 он				
			I улирал	II улирал	III улирал	IV улирал	
1	2	3	4	5		6	
1	Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа, байгаль орчныг хамгаалах, хог хаягдлыг бууруулах талаар ажилчдыг хамруулсан сургалт зохион байгуулах	800000	+	+	+	+	Хөдөлмөрийн аюулгүй байдал хариуцсан инженер
2	Дотоод хяналт шалгалтын журмыг боловсруулан, хэрэгжүүлж ажиллах	200000		+	+	+	Хүний нөөцийн менежер
Нийт		1000000					

12. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнах төлөвлөгөө

Өмнөговь аймгийн Ханбогд сумын 1 дүгээр багийн иргэдэд БОМТ-нд тусгагдсан нүүрс ачилт, буулгалтын талбайн орчин дахь ард иргэд, олон нийтийг хамарсан ажил, арга хэмжээний төлөвлөгөө, удирдамжуудыг тухай бүр танилцуулж, хэрэгжсэний дараа ажлын тайлан, мэдээг цаг хугацаанд нь тайлагнаж ажиллана.

**Хүснэгт 13. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсэд
оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө**

№	БОМТ, БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	Зохион байгуулах газар
	1	2	3	4	5	6	7
1	Харьяа багийн ард иргэд, орон нутгийн захиргааны байгууллагын алба хаагчид	Танилцуулга уулзалт зохион байгуулах	Байгаль орчныг хамгаалах, үйл ажиллагааны талаар мэдээлэл түгээнэ.	Жил бүрийн III улиралд багтаан хэрэгжүүлнэ.	1200000	Захиргаа, аж ахуйн албаны дарга, Байгаль орчны асуудал хариуцсан инженер	Харьяа багийн төвийн байранд
	Нийт				1200000		

13. Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Нүүрс ачилт, буулгалтын талбайн үйл ажиллагааны үед байгаль орчинд учруулах сөрөг нөлөөлөл, байгаль орчинд гарсан өөрчлөлтийг тухай бүр илрүүлэх, түүнийг бууруулах, арилгах зорилгоор байгаль орчны төлөв байдалд тодорхой орон зайд, тодорхой хугацааны дотор, тодорхой давтамжтайгаар ажиглалт, хэмжилт, хяналт явуулах ёстой. Үүнд тулгуурлан үйл ажиллагааны явцад байгаль орчинд учруулж буй нөлөөлөл, түүний хэмжээ, цар хүрээ, байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдэд гарч буй өөрчлөлтөд дүгнэлт хийж цаашид авах арга хэмжээг нарийвчлан төлөвлөж хэрэгжүүлнэ. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцад байгаль орчны төлөв байдалд өөрчлөлт орох, бохирдлын хэмжээ байгаль орчны стандарт, норм нормативаар тогтоосон хэмжээнээс хэтэрч илрэх тохиолдолд мэргэжлийн байгууллагад яаралтай хандаж, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлж ажиллана.

Хүснэгт 14. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

№	Хяналт шинжилгээний үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал (төг)	Нийт зардал (төг)	Тайлбар	Баримтлах стандарт, арга, аргачлал
1	2	3	4	5	6	7	8	
Агаар								
1	- Тоос (TSP) эсвэл PM10, PM2.5 - SO ₂ - NO ₂ - Дуу шуугиан	Талбайн хэмжээнд	Жил бүрийн II, III улиралд	2	200000	400000		MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага
Хөрс								
2	Физик-химийн үзүүлэлт	Ногоон байгууламжийн хэсэг	Жилд 2 удаа	2	150000	300000		MNS 3297:2019 Байгаль хамгаалал. Хөрс. Хот, суурин газрын хөрсний эрүүл ахуйн аюулгүйн үзүүлэлт, бохирдлыг үнэлэх
3	Хүнд металлын үзүүлэлт	Ашиглаж буй газрын сул хөрстэй хэсэг, 2 цэгт	Жилд 2 удаа	2	250000	500000		MNS 5850:2019 Хөрсний чанар. Хөрсөнд агуулагдах бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ
4	Газрын тосны бүтээгдэхүүн	Талбайн зам дагууд, 2 цэгт	Жилд 1 удаа	1	650000	650000		
5	Хяналт шинжилгээг мэргэжлийн байгууллагаар хийлгүүлэх		Жилд 1 удаа		3000000	3000000		
	Нийт					4850000		